

БАТЛАВ
"ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ"
ТӨҮГ /цаашид "ЗАХИРАЛ"
Ч.САРАНЖАВ

БАТЛАВ
"ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ-3"
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.ДАМДИНСҮРЭН

"ДЦС-3" ТӨХК-ИЙН ХҮЧИН ЧАДЛЫГ 250 МВТ-ААР ӨРГӨТГӨХ ТӨСЛИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГУУЛАХ, ҮР АШГИЙН ТООЦОО, СУДАЛГАА ХИЙХ, ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ТЕХНИКИЙН ШИЙДЭЛ БОЛОН МАТЕРИАЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН СОНГОЛТОД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ АЖЛЫН ГЭРЭЭ

2017 оны 4. сарын 17 өдөр

Дугаар *2017/28/17* Улаанбаатар хот
1-4-188/17

Нэг талаас "Дулааны цахилгаан станц-3" ТӨХК /цаашид "захиалагч" гэх/-ийг төлөөлж Тэргүүн дэд захирал, ерөнхий инженер Ү.Төмөрхуяг, нөгөө талаас Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ /цаашид "гүйцэтгэгч" гэх/-ийг төлөөлж Ерөнхий инженер Б.Дашдондог нар Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 8-р сарын 24-ний өдрийн 57 дугаар тогтоол, Барилга захиалагчийн дүрэм, ДЦС-3 ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 12 тоот тогтоолыг тус тус үндэслэн "ДЦС-3" ТӨХК-ийн хүчин чадлыг 250 МВт-аар өргөтгөх төслийн бэлтгэл хангах ажлын хүрээнд үр ашгийн тооцоо, судалгаа хийх, төлөвлөгөө боловсруулах, техникийн шийдэл болон материал, тоног төхөөрөмжийн сонголтод зөвлөгөө өгөхөд хамтран ажиллахаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017-2020 онд баригдах "ДЦС-3" ТӨХК-ийн 250МВт-ийн өргөтгөлийн төслийн бэлтгэл хангах ажлын хүрээнд хүрээнд үр ашгийн тооцоо, судалгаа хийх, төлөвлөгөө боловсруулах, техникийн шийдэл болон материал, тоног төхөөрөмжийн сонголтод зөвлөгөө өгөхтэй холбогдуулан талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг хариуцлагыг тогтооход гэрээний зорилго оршино.
- 1.2 Энэхүү гэрээ нь "ДЦС -3" ТӨХК-ийн 250 МВт-ийн өргөтгөлийг гүйцэтгүүлэх ажил дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хоёр. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1 ДЦС-3 ТӨХК-ийн хүчин чадлыг 250 МВт-аар өргөтгөх төслийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд үр ашгийн тооцоо, судалгаа хийх, төлөвлөгөө боловсруулах, техникийн шийдэл болон материал, тоног төхөөрөмжийн сонголтод зөвлөгөө өгөх ажлыг мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ.
- 2.2 Төслийн үр ашгийн тооцоо, судалгаа хийх, төлөвлөгөө боловсруулах, техникийн шийдэл болон материал, тоног төхөөрөмжийн сонголтод зөвлөгөө өгч барилга угсралт болон тоног төхөөрөмжийн ажлын зураг, төсөл боловсруулах ажлын явц, чанар, гүйцэтгэлд хяналт хийнэ.
- 2.3 Барилга угсралт, тоног төхөөрөмжийн ажлын зураг, төсөл боловсруулах болон бэлтгэл ажлын явцад гарсан асуудлуудыг цаг тухайд нь шийдвэрлэж, шаардлагатай тусламж дэмжлэгийг үзүүлж байх үүрэгтэй.

ХҮЧНИЙ Х
ТӨВ
2017.04.17

Батлав

- 2.4 ЭХХТ нь захиалагчийн нэрийн өмнөөс гэрээнд заасан үүрэг даалгавруудыг хийлгэх бүх төрлийн арга хэмжээ авч ажиллах бүрэн эрхтэй байна.
- 2.5 "ДЦС-3" ТӨХК-ийн 250 МВт-ын өргөтгөлийн төслийн бэлтгэл ажил хангуулах, ажлын зураг төсөл боловсруулахад хяналт инженерүүдийг ажлын өдөрт 4 цагаас багагүй хугацаагаар ажлын байранд ажиллуулах, ажлын зураг төсөл экспертизээр батлуулах, холбогдох барилгын болон тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөл олгуулах, хил гааль болон бусад хууль эрх зүйн дэмжлэг тусалцаа үзүүлнэ.
- 2.6 Бэлтгэл ажлын хүрээнд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, төслийн талбайн зохион байгуулалт, эмх цэгц, ариун цэвэр, дэг журмыг мөрдүүлэхийг шаардах эрхтэй.
- 2.7 Ажлын зураг, төсөвтэй барилга угсралтын ажлын хэмжээ, материалын чанар, зарцуулалт зэрэг нь тохирч байгаа эсэхийг тогтоох төлөвлөгөө судалгаа гаргах.
- 2.8 Тус төслийн гэрээнд заагдсан захиалагчийн гүйцэтгэх үүрэг хариуцлага болон эрхийг захиалагчийг төлөөлөн хэрэгжүүлэх бүрэн эрх үүрэгтэй байна.
- 2.9 ЭХХТ нь энэхүү гэрээний чиг үүргийг хэрэгжүүлэхдээ өндөр ур чадвар бүхий мэргэжилтэн, хуулийн этгээдүүдийг тохиролцон ажиллуулж болно.
- 2.10 ЭХХТ ТӨХК нь 250 МВт-аар өргөтгөх төслийн бэлтгэл хангах ажлын хүрээнд үр ашгийн тооцоо, судалгаа хийх, төлөвлөгөө боловсруулах, техникийн шийдэл болон материал, тоног төхөөрөмжийн сонголтод зөвлөгөө дэмжлэг үзүүлнэ.

Гурав. ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ-3 ТӨХК-ИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 ДЦС-3 ТӨХК нь өргөтгөлийн төслийн үр ашгийн тооцоо, судалгаа хийх, техникийн шийдэл гаргах, материал, тоног төхөөрөмжийн сонголт хийх төлөвлөгөө боловсруулах ажилд шаардагдах тоног төхөөрөмжүүдийн стандарт, нормууд гэрээт ажил эхлэхээс өмнө ЭХХТ-д хүлээлгэн өгсөн байна.
- 3.2 Өргөтгөлийн зураг төслийг боловсруулахдаа Монгол улсад мөрдөгдөж байгаа норм, стандартын дагуу хийж гүйцэтгээгүй, чанаргүй хийсэн ажлыг засах, гүйцээн хийхийг гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.
- 3.3 Монгол улсад мөрдөгдөж байгаа дүрэм, журам, норм, стандартын дагуу бүрэн гүйцэд хийгдэж дууссан ажлын зураг, төсвийг баталгаажуулалт хийхийг холбогдох ажилтнаас шаардах эрхтэй.
- 3.4 Шаардлагатай үед бусад төрлийн байгууллагуудаас элдэв зөвшөөрөл, хууль эрх зүйн зөвшилцөл зэрэгт захиалагчаас тусламж дэмжлэг авах эрхтэй.
- 3.5 Ажлын зураг төсөв боловсруулах явцад үндсэн болон туслах тоноглолын техникийн сонголт хийх ажилд ЭХХТ-ийн төлөөлөлийг байлцуулан хянуулж, гарын үсэг зуруулж чанарыг баталгаажуулах

Дөрөв. ТӨЛБӨР ТООЦОО

- 4.1 ДЦС-3 ТӨХК нь хүчин чадлаа 250 МВт-аар өргөтгөх төслийн бэлтгэл хангах ажлын хүрээнд үр ашгийн тооцоо, судалгаа хийх, техникийн шийдэл гаргах, материал, тоног төхөөрөмжийн сонголт хийх төлөвлөгөө боловсруулах ажлын зардалд 200,000,000.00 /хоёр зуун сая/ төгрөгийн төлбөрийг гэрээ батлагдсанаас хойш 7 хоногийн дотор ЭХХТ-ийн дансанд шилжүүлнэ.

Тав. ХАРИЛЦАН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА



- 5.1 Гэрээ байгуулсан талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг буруутай этгээд бүрэн хариуцна.
- 5.2 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагчийн өмнө гүйцэтгээгүй ажлын хэмжээгээр хариуцлага хүлээх бөгөөд шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.


Зургаа. БУСАД ЗҮЙЛ

- 6.1 Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр гэрээний хугацааг дуусгавар болсонд тооцно.
- 6.2 Энэхүү гэрээтэй холбогдон талуудын хооронд гарч болзошгүй маргааныг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Талууд нь гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд эс хүрч чадваас шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.
- 6.3 Гэрээнд заагаагүй нэмэлт ажлыг энэхүү гэрээгээр зохицуулахгүй бөгөөд талууд тохиролцсон тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулах эсхүл нэмэлт гэрээ байгуулж болно.
- 6.4 Энэхүү гэрээг 4 хувь үйлдэж талууд тус бүр 2 хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хуулийн адил хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“ЭХХТ”-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:


ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

 Б.ДАШДОНДОГ
СБХ-ИЙН ДАРГА

 Х.ГАЛСАНХҮҮ
ГХАТХХ-ИЙН ДАРГА

 З.МӨНХБАТ

ЗУХ, ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН


 Б.БАТБОЛД

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот,
ХУДүүрэг, Чингисийн өргөн чөлөө-36,
Эрчим хүчний хөгжлийн төв
Утас: 7711 6040,
Факс: 7000 2457
Харилцах банк: Голомт
Дансны дугаар: 2105010095


“ДЦС-3” ТӨХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

 Ү.ТӨМӨРХУЯГ
ТХХ-ИЙН ДАРГА

 Д.ТӨМӨРБААТАР
ТБХ-ИЙН ДАРГА

 Г.АМАРТҮВШИН
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

 Ч.ЧУЛУУНЧИМЭГ
ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

 Г.БАТНЯМ
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

 Ч.ЭНХЗУЛ

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот,
ХУДүүрэг, 3-р хороо, Өөрийн байр

Утас: 343024, 341717
Факс: 341991, 343024
Харилцах банк: ХХБ
Дансны дугаар: 406001038